

**Удирдах ажилтнуудын 08 дугаар сарын 22-ны өдрийн
шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн биелэлт**

2022 оны 09 дүгээр сарын 05

№	Өгөгдсөн үүрэг, даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
1.	09 дүгээр сард Аймгийн Засаг дарга, орлогч дарга нарын оролцох үйл ажиллагааны сарын мэдээгээ ТЗУХ-т ирүүлэх	2022.09.02	Бүх байгууллага	<p>Аймгийн Засаг дарга, орлогч даргын 09 дүгээр сард оролцох үйл ажиллагааны мэдээллийг нийт 35 байгууллага ирүүлсэн байна. Үүнээс аймгийн Засаг дарга, орлогч дарга нар оролцох 9 үйл ажиллагаа байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас “Аймгийн барилгачдын баярын арга хэмжээ” 09 дүгээр сарын 07-ны өдөр 2. Хүнс, хөдөө аж ахуйн газраас “Говийн бүсийн намрын үзэсгэлэн худалдаа” 09 дүгээр сарын 09-10-ны өдрүүдээр 3. Эрүүл мэндийн газраас “ХСҮТөвтэй хамтран хавдрын эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулна” 09 дүгээр сарын 26-30-ний өдрүүдэд 4. Биеийн тамир спортын газраас “Үндэсний сурын харвааны тэмцээн” 09 дүгээр сарын 20-26-ны өдрүүдэд 5. Биеийн тамир спортын газраас “Монголын ард түмний 15 дугаар их наадмын шигшээ тэмцээн” 09 дүгээр сарын 09-18-ны өдрүүдэд 6. Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас “Ажил хийх гоё” өдөрлөг, арга хэмжээ 09 дүгээр сарын 26-ны өдөр 7. Соёл урлагийн газраас “Соёл, урлагийн ажилтнуудын баярын арга хэмжээ” 09 дүгээр сарын 01-20-ний өдрүүдэд 8. Соёл урлагийн газраас “Номын баяр” 09 дүгээр сарын 11-15-ны өдрүүдэд 	100
2.	<p>Нийтийн эзэмшлийн талбайн зэрлэг, шарилжийг цэвэрлэх</p> <p>Сумдууд хувиар гарган байгууллагууд хуваарьласан зэрлэгийг цэвэрлэх</p>	2022.09.05	Сумдын Засаг дарга нар Тохжилт сүмбэр Бүх байгууллага	<p>Хуваариласан зэрлэг цэвэрлэх ажлын хүрээнд:</p> <p>Сүмбэр сум: Аж ахуйн нэгж байгууллагуудад сумын Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А\59 дүгээр захирамжаар батлагдсан хуваарийн дагуу хариуцсан газрынхаа зэрлэгийг зулгаах ажлыг зохион байгуулж нийт 33 байгууллага цэвэрлэж 3 тн шарилжийг цэвэрлэн хогийн цэгт зөөж тээвэрлэсэн байна. Цэвэрлэгээнд оролцоогүй байгууллага байхгүй байна.</p> <p>Шивээговь сум: Сумын төв талбайн шарилж, зэрлэг ургамлыг цэвэрлэх ажлыг 6 байгууллага, 16 ААНэгжийн 52 албан хаагч оролцон нийтдээ 4тн гаруй шарилжийг цэвэрлэн төв хогийн цэгт зөөж тээвэрлэсэн байна. Цэвэрлэгээнд оролцоогүй байгууллага байхгүй байна.</p> <p>Баянтал сум: 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдөр 5 төсвийн байгууллагуудад нийтийн эзэмшлийн бүх талбайн зэрлэгийг цэвэрлүүлэхийн тул хуваарилан өгч цэвэрлүүлсэн байна. Гарсан 3 тонн</p>	100

				хог хаягдлын хогийн цэгт зөөвөрлөн хаясан. Цэвэрлэгээнд оролцоогүй байгууллага байхгүй байна.	
3.	Цэцэрлэг, сургуулийн ариутгал халдваргүйтгэлийг шалгах, халдвар хамгаалалтын зөвлөгөө мэдээлэл өгөх.	2022.09.05	Шуурхай штаб	Аймгийн хэмжээний 5 сургууль, 6 цэцэрлэг, 3 гал тогоо, 4 дотуур байранд хяналт шалгалтыг 08 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтран зохион байгуулсан. Мөн ариутгал халдваргүйтгэлийг “Сүмбэр гурван бат” ХХК-тай хамтран 100 хувь ариутгал халдваргүйтлийг хийсэн байна. Сургууль, цэцэрлэгүүдэд Эрүүл мэндийн яамны “Ковидын халдвараас урьдчилан сэргийлэх тухай” 377 дугаар зөвлөмжийн дагуу ажиллах талаар албан бичгээр хүргүүлсэн байна.	100
Нийт					100

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС